



## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 06 сарын 11 өдөр

Дугаар А/168

Сүхбаатар сум

### Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1"а", Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6, 23.7, 23.11 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дэлхий нийтэд тархаад буй "Covid-19" цар тахлын улмаас улс, орны эдийн засагт хүндрэл үүсч, аймгийн төсвийн орлого тасарч байгаатай холбогдуулан төсвийн орлогыг бүрдүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлж, татварын хуримтлагдсан өр, авлагыг бууруулах зорилготой ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:

О.Мөнхбаяр

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Гишүүд:

Б.Саруултөгс

-Газрын харилцаа, барилга хот байгуулалтын  
газрын дарга

З.Түвшинтөгс

-Байгаль орчин, аялал жуулчлалын газрын  
Дарга

Д.Цэрэнболд

-Татварын хэлтсийн дарга

Б.Болормаа

-Санхүү, төрийн сангийн хэлтсийн орлого,  
бүртгэлийн мэргэжилтэн

2. Татварын тухай хуулийн шинэчлэлийн хүрээнд Төсвийн орлогыг бүрдүүлэх, татварын өр, авлагыг барагдуулах ажлыг шуурхай зохион байгуулж, холбогдох хууль, журамд нийцүүлэн татварыг нөхөн төлүүлэхийг ажлын хэсгийн ахлагч, аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /О.Мөнхбаяр/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ

C:\users\albanbichig2020\zahiramjA4.docx

438891537